

Австральд болсон WCDN 8 дахь удаагийн Олон улсын Христэч эмч нарын чуулганы үеэр тавигдсан илтгэл,гэрчлэлүүд

## Эрх мэдэлт хүчит үйлсүүд

### «Арьсны өвчний улмаас олон хүмүүс зовдог байсан боловч цэвэрхэн эдгэрсэн юм»

Доктор Ким Жүн сөн (1-р их тойрог 4-р бүлэг, Хүүхдийн их эмч)



Би Дэлхийн христэч эмч нарын цугларалт болох WCDN (Дэлхийн Христэч Эмч нарын холбоо)-ны Солонгос дахь сүлжээний даргынхаа хувьд Австральд болсон 8 дахь Олон улсын Христэч эмч нарын чуулганд арьсны өвчний тухай эдгэрлийн гэрчлэлүүд болон илтгэл тавьсан билээ.

Харшлын дерматит, арьсны үрэвсэл, хайрст үлд, цэврүүтэх, экзем, ба архаг болон эмнэлэг дерматит, арьс салстын болон энэ бүх төрлийн арьсан дээрх үрэвслийн тухай юм. Зарим өвчтнүүдийн хувьд бактерийн гаралтай халдвартай байсан болохоор хүчтэй үрэвслийн эсрэг ба бактерийн эсрэг эм тэдэнд хэрэгтэй байлаа.

Заримдаа хайрст үлд эсвэл харшлын дерматит үрэвсэл нь удамшлаас үүдэлтэй бөгөөд эм, эмчилгээний технологи

хөгжсөн байсан ч тэднийг эдгэх нь маш хэцүү юм. Мөн түүнчлэн хүмүүст олонтоо тохиолддог нь арьсан дээр олон яр шарх ба идээт үрэвсэлүүд дахих ба өөр янз бүрийн хамтарсан өвчтэй болдог нь. Яг энэ мөчид ч үй олон хүмүүс ийм төрлийн өвчнүүдээс болоод зовж байна.

Миний илтгэл тавих сэдэв бол үүнтэй адил бүх төрлийн арьсны өвчний тухай юм. Энд дурдах өвчтнүүд нь бүгдээр ямар нэгэн эмнэлэг ба эмчилгээнд найдаагүй бөгөөд зөвхөн Бурханы эрх мэдэлт хүчээр эдгэрхийг хүсэж байсан нь үнэн билээ. Библид бичигдсэнчлэн Бурхан ба өөрийнх нь хооронд босож хураагдсан гэм нүглийн ханыг нурааж, итгэлээрээ залбирал авахад тэр өдөртөө, эсвэл хэд хоног дараа л гэхэд өвчтэй хүн тус бүр маш хурдан хугацаанд эдгэрсэн билээ. Тэдэнд ямар ч сорви ба элдэв хамтарсан

өвчин, хөндүүр зовнуур байхгүй бөгөөд дахиад гараагүй төгс эдгэрсэн ба одоо ч тэд бүгдээрээ эрүүл, аз жаргалтай амьдарч байгаа билээ.

Дэлхийн 27улс орноос ирсэн 220 эмч нар энэ эдгэрлийн гэрчлэл ба илтгэлийг сонсоод маш их гайхаж Бурханыг алдаршуулсан юм. Төгс хүчит Бурханы эрх мэдэлт хүч ба хүн төрөлхөнд хайртай Доктор И Жей руг пасторын чин сэтгэлийн залбирлаар дамжуулан орчин үеийн анагаах ухаанаар эдгээж чадахгүй өвчнүүд маш хурдан төгс эдгэрлэг юм.

Эцэст нь төрлийн бүрийн арьсны өвчнүүд нь Бурханы эрх мэдэлт хүчээр бүрэн эдгэрэх боломжтой бөгөөд үүний тулд чин сэтгэлийн гэмшил ба итгэлийн залбирал чухал юм. Тиймээс бие махбодийн эдгэрлийн өмнө сүнс зүгийн эдгэрэлт маш чухал юм.

#### Харшлын дерматит арьсны үрэвсэл

Ким Су гён эгч дүү (20 настайдаа, Пусан)



Тэр 2002 онд залбиралыг хүлээн авсныхаа дараа харшлын дерматит арьсны үрэвслээс эдгэрсэн юм. Гэвч зохисгүй зүйл үйлдэн, 2004 оны зун дахих тууралт гарсан билээ. 2005 оны 7-р сард тэр залбирал аваад төгс эдгэрсэн юм. Түүнээс хойш одоог хүртэл ямар ч шинж тэмдэггүй эрүүл амьдарч байна.

#### Цэврүүлэх экзэм

Мүн Хэй ран эгчдүү (22 настайдаа Гуанжү)



2009 оны 8 сарын 9-нд түүний хоёр хөл ба шилбээр хавдаж өвдөн, 8 сарын 10-нд шархлаа үүсч, шүүс ялгаран өвчин нь хүндэрсэн юм. 8 сарын 22-нд залбирал авсны дараа, шархлаанууд нь тав сууж өвчин хөндүүр нь багассан бөгөөд 9 сарын 23-нд тэр төгс эдгэрсэн юм.

#### Харшлын дерматит арьсны үрэвсэл

Пак Сей хи эгч дүү (16 настайдаа Еесү)



2007 оны зургаан сард харшлын дерматит үрэвсэл нь түүний хөл, гарт бий болж нүүр хүртэл нь тархав. 2007 оны 9 сарын 7-нд тэр залбирал аваад түүний шархнаас шүүс ялгарах нь зогсож, загатнахаа болив. 2007 оны 10 сарын 5-нд хоёр дахь залбирал авснаас хойш 2-3 хоногийн дараа түүний бүх шархнууд тавлаж унаснаар цаанаас нь шинэ арьс гарч ирсэн бөгөөд одоо төгс эрүүл болсон юм.

#### Идээтэй хайрст үлд


Ким А хён эгч (33 настай, Пусан)



2004 онд түүний зүүн гарын хуруунуудад цэврүүтэй үлд мэт зүйл гарч ирэв. 2005 оны 10 сард шархалж шүүс ялгарч эхэлсэн ба нэг долоо хоногийн дараа идээлж, шархалсан хэсгүүд нь нүүр болон баруун гар хүртэл тархаж шүүрээд хавдаж эхлэв. 2005 оны 10 сарын 22-нд тэр залбирал авсан юм. Нэг долоо хоногийн дараа түүний шархнууд нь маш хурдан хатаж, тавлан унаж эв эрүүл болсон юм.

#### Архаг диатез

Юү Бин (6 настайдаа Жөнжү)



2008 оны 4 сарын сүүлээр арьсны өвчин илэрсэн ба архаг диатез гэж оношлогдов. 2008 оны 9 сард тэр гурван удаагийн залбирлын үр дүнд 2008 оны 10 сард тэр төгс эдгэрсэн билээ.

#### Халууны гоц халдварт хавдарын өвчин

Чой, Сон сүг (37 настайдаа Сөүл)




2 сарын 26-нд тэр их халуурч, 27-нд түүний хацар хавиар арьс улайраад хавдав. Толгой нь эргээд тэр нүд нь эрээлжилж байсан ба түүнийг халууны гоц халдварт хавдарын өвчин гэж оношлов. 2 сарын 29-нд болсон Баасан гаригийн өвчин эдгээх цуглааны үеэр залбирал авсны дараа тэр халуурахаа болив. 3 сарын 2-нд хавдар нь байхгүй болсон ба дараагийн өдөр нь тэр төгс эдгэрч арьс сэргэсэн юм.

#### Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

#### Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)




**Хаяг:** Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С  
**Утас:** чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 917-0773

www.manmin.org  
www.manmintv.org

# Манмин Мэдээ

## «Эрдэнэсийн дундах эрдэнэ бол ИТГЭЛ ЮМ»

Оргүй хоосноос бодит байдлыг бий болгох итгэлээр Манмин төв сүм нь байгуулагдаад 29 жилийн дотор 9,000-гаад салбар сүм болон хамтарсан сүмтэй болов.



1982 онд сүм байгуулагдснаас хойш Ариун Сүнсний гал мэт нөлөөгөөр дэлхий даяар эрчимтэй бөгөөд асар хурдацтайгаар өсөж, 9000-гаад салбар сүм, хамтарсан сүмүүдтэй Манмин Төв Сүмийн үйл ажиллагаа. (Зүүн талаас, 1982 онд анхны нээлтийн мөргөлийн үйл ажиллагаа, 1992 оны Ариун Сүнсний нэгдсэн их цуглаан, 2002 оны Энэтхэгийн нэгдсэн их цуглаан, 2006 оны АНУ-д Нью-Йоркын нэгдсэн их цуглаан, 2009 оны Израйлийн Нэгдсэн их цуглаан, 2010 оны Сүмийн 28 жилийн ойн баярын үйл ажиллагаа болон GCN-н 5 жилийн ойн баярын үйл ажиллагаа).

1982 оны 7 сарын 25нд БНСУ Сөүл хот Тунжаг дүүрэг Шиндэбан хороонд 36 м2 талбайтай сүмд хүүхэд том хүн нийлсэн 13 хүнтэй 7 мянган воны хоронгөтэйгөөр Манмин Сүм анх нээлтийн мөргөлөө хийж, үйл ажиллагаагаа эхэлсэн юм. Энэхүү нээлтийн үйл ажиллагаанд И Жей руг номлогч “Эрдэнэсийн дундах эрдэнэ бол итгэл юм” гэдэг сэдвээр сургаал айлдсан билээ. Түүнээс хойш зөвхөн дуулгавартай байдлаар итгэлээрээ давшин ирсэн бөгөөд үүний үр дүнд сүм байгуулагдснаас хойш 29 жилийн дотор 9000-гаад салбар сүм, хамтарсан сүмүүдтэй болж, дэлхийг нэгтгэх агуу үйлсийг биелүүлж буй анхны цуглаан мэт сүм болсон юм.

Доктор И Жей руг Тэргүүн пастор нь 7 жилийн турш хүнд

өвчтэй байсан тэрээр Амьд Бурхантай уулзан, тэр л агшинд бүхий л өвчнөөсөө эдгэрсэн бөгөөд, Бурханыг нэгт хайрлах сэтгэлээр үг сургаалын дагуу амьдарч байхдаа Эзэний боолын дуудлагыг аваад сүм байгуулахын төлөө итгэлээрээ залбирч байсан юм. Бурханы хувьд боломжгүй зүйл гэж байдаггүй бөгөөд юуг ч хийж чадна гэдэгт итгэж байсан Тэрээр хамаатан, садан ба өөр хэний ч тусламжыг аваагүй юм. Гал мэт залбирсны үр дүнд сүмийн байр, индэр, утас, төгөлдөр хуур зэрэг залбирч гүйснх нь дагуу бүх зүйлүүдийг нь хариулж өгч байлаа.

Ариун библийн Үйлс номонд бичигдсэнтэй адил анхны цуглаан шиг олон тэмдэг, гайхамшигууд мөн эрх мэдэлт хүчит үйлсүүд гарч, Ариун Сүнсний бялхал

дотор Бурханы үг тунхаглагдаж, итгэгч гишүүдийн итгэл хурдан өсч, итгэгчдийн Ариун Сүнсний бялхал дүүрэн залбирал ба сайн мэдээ тараалтаар дамжуулан сэргэлтээ сэргэлтийг хураан авч байна. Түүнчлэн итгэгчид Тэргүүн пастортайгаа нэгдэн, үг сургаалд дуулгавартай байснаар Бурхан Өөрөө удирдан, Солонгосын орон нутагт төдийгүй дэлхий даяар, хүн төрөлхтөний төлөө үйлчилдэг сүм болон өрсөсөн билээ.

1990 онд номлолын эрчимтэй үйл ажиллагаа ба сүмийн их сэргэлтийн үр дүнд Америкийн “Christian World” сэтгүүлд “Дэлхийн шилдэг 50-н сүмүүд” ийн тоонд багтснаар Солонгост сайн мэдээ тараах үйлсийн тэргүүн эгнээнд зогсож, 2000 оноос хойш үйл ажиллагааныхаа хүрээг тэлж, Энэтхэг, АНУ, ОХУ

зэрэг гадаадын олон оронд хэдэн арван мянга, хэдэн зуун мянга болон сая сая хүмүүс цугларсан нэгдсэн их цуглаануудыг удирдан явуулж, дэлхий дахинаа авралын зарыг тунхаглаж байна. Ялангуяа, 2009 онд Израйльд аврал зар түгээсэн нь түүхэнд тэмдэглүүштэй үйл явдал болсон юм.

Энэ төдийгүй олон орны хэл дээр орчуулагдан гарч буй номууд ба олоогын байдлаар 20 гаруй хэлээр орчуулагдан гарч буй сүмийн мэдээний сонин “МанМин Мэдээ” сонин, GCN(Христийн Нэгдсэн Сувар), WCDN (Дэлхийн Христэч Эмч нарын холбоо), MIS (Манмин Олон Улсын Библийн сургууль) –аар дамжуулан Бүтээгч Бурхан ба Есүс Христ, АриунСүнсний эрх мэдэлт хүчийг таниулан, ариун сайн мэдээг

тунхаглан тарааж байна.

Доктор И Жей руг Тэргүүн пастор нь Солонгосдоо ч гадаад руу ч сайн мэдээ тараах Эзэний боол, Сайн мэдээ тунхаглагчдыг томилон илгээхдээ ингэж захиж хэлдэг юм. “Юу ч байхгүй байлаас эхэл. Бурхандаа залбирал нэг нэгээр нь залбирлынхаа хариуцуудыг олоорой. Эзэний боол нь зөвхөн үг ба залбирлаар л амьдрах хэрэгтэй. Гал мэт халуун залбирал хурдан ариун байдлыг олж, Эрх мэдэлт хүчийг авараар. Сүнслэг зүрх сэтгэлтэй болол Бурхан гуйсан болгонд тань хариулж өгөн, сүмийг аяндаа сэргээхд тусалж өгнө. Мөн миний гэр бүлээс илүү Бурханы өгсөн хоньдууд болох итгэгч наргаа илүү хайртай байх билээ.”



“Загалмайн Сайн Мэдээ” Цувралууд (13)

# Есүс өргөст титэм зүүсэн нь

“Тэд Есүст час улаан нөмрөг өмсгөж, үүргэнээр титэм сүлжээд Түүний дээр тавиад,-Иудейчүүдийн Хаан, мэнд хүргэе гэж тохуурхаж байв. Тэд Түүний толгойг хулсаар цохилж, Түүний өөдөөс нулимж, өвдөг сөхрөн Түүнд мөргөсөөр байлаа.” (Марк 15:17-19).

Есүсийн амсаж туулсан зовлонгийн тухай нарийн тодорхой мэдэх юм бол Бурханы хайрыг илүү гүнзгий ухаарч, гал халуун итгэлийн амьдралаар амьдрах болдог. Есүс яагаад ташуурдуулан, цусаа урсгасны утга учир, мөн яагаад өргөст титмийг зүүсний утга учрыг мэдэх л юм бол Бурханы хайранд сэтгэл хөдлөхгүй байхын аргагүй юм. Өнгөрсөн удаа Есүс яагаад ташуурдуулан цус урсгасны утга учрыг тайлбарласан бол энэ удаад үргэлжлүүлэн яагаад Есүс өргөст титэм зүүсний утга учрын талаар тайлбарлая .



Доктор И Жаерок Тэргүүн Пастор

## 1. Есүс өргөст титэм зүүсний утга учир

Есүс нь Бурханы Хүү бөгөөд алдар суу ба хүндэтгэлийг хүртэх төдийгүй, алдар сур жавхлантай титмийг зүүх нь зохистой Эрхэм билээ. Хэдий тийм ч гэсэн Тэрээр загалмайн зовлонг туулан, хурц өргөст титмийг зүүсэн билээ (Марк 15:17). Ромын цэргүүд урт бас хатуу өргөстэй модны мөчрөөр хүний толгойноос арай жижиг титмийг сүлжээд, Есүсийн толгой дээр хүчээр дарж утган зүүсэн юм.

Урт бөгөөд маш хурц, хатуу өргөсүүд Есүсийн толгой руу хатган шивж нэвтрэхэд, Түүний хуйх нь урагдах өвдөлттэй хамт толгойноос маш их цус нүүр рүү нь урсан бүрхэж байсан юм. Есүс яагаад ингэж цусаа урсгаж өргөст титмийг зүүсэн бэ? Үүний утга учир нь юу юм бол? Энэ нь хүмүүсийн бодол санаагаар хийдэг гэм нүглүүдийг уучилж өгөхийн төлөө юм.

Хүний зүрх сэтгэлд худал хуурмаг, үнэн бус шинж чанар байдаг учраас ийм үнэний бус бодлуудыг бодож атгаж хорон муу байдлыг сэтгэлдээ агуулдаг. Энэ дэлхийд хичнээн атгаж хорон бодол санаа зүрх сэтгэлдээ хадгалж байсан ч үйлсээр илэрхийлэгдээгүй бол гэм нүгэл биш гэх боловч Библид зүрх сэтгэлдээ атгаж хорон бодол санааг агуулах ба бодол санаагаар дамжуулан үнэний бус, атгаг, худал хуурмаг бодлууд болоход л гэм нүгэл гэдэг айлдсан байдаг билээ. (Матай 5:28, 1 Иохан 3:15).

Хүний тархинд сурсан мэдлэгүүд нь байдаг ба түүнийгээ эргэн санах, хэрэгжүүлэх ой санамж гэж байдаг юм.Энд хүний төрснөөс хойш үзэж харсан, сонсож, сурсан бүхий л зүйлс хадгалагдаж бөгөөд үүнийг мэдлэг гэдэг. Гэвч хүн болгоны өсөж торнисон орчин, нөхцөл байдал өөр өөр ба сурч хүмүүжүүлэгдсэн байдал нь ч өөр өөр байдгийг харж болно. Яг ижил нөхцөл байдалд мөн нэг хүнээр заалгасан ч хүн тус бүр яаж хүлээн авч, ямар мэдрэмжээр сурсан бэ гэдэг нь харилцан адилгүй учир эцсийн үр дүн нь ч өөр өөр байдаг ба тухайн хувь хүнийхээ хувьд сайн мууг ялгах чадвар болон хэмжүүр нь ч өөр өөр байдгийг харж болно.

Үүнчлэн мэдлэгүүд нь шаардлагатай үед эргэн санаан гарч ирэхийг “Бодол” гэдэг бөгөөд дээр дурьдсанчлан хүн болгоны мэдлэг нь өөр өөр байдгийн улмаас хүмүүс асдихан үйл явдлыг харсан ч өөр өөрөөр боддог билээ. Тийм учраас нэгэн улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн үйлдэл нь өөр нэгэн улс оронд бүгдүйд, хүний ёсноос гажсан үйлдэл гэх мэтчилэн шүүмжлэгддэг болохыг харж болно.

Түүнчлэн хүн төрөлхтөний бодол санаануудыг сатан захирч байдаг бөгөөд дийлэнх нь үнэний бус бодол санаа байх нь мэдээжийн хэрэг билээ.

Жишээ нь нэг хүн сайшаагдахад, өөр нэгэн хүнийг сатан үнэн бус зүйлсийг захирдаг болохоор сэтгэл тавгүйрхэл ба санаагаар унах байдал руу хөтөлдөг. Харин хэрэв тэр хүнд үнэний л мэдлэг байгаа бол сатан түүний бодлуудыг захирч чадахгүй ба тэр зөвхөн, “Тэр сайшаагдаж байгаа нь сайн хэрэг юм. Сайхан байна” гэж бодож үнэнгэй хамт төршлэдэг болохыг харж болно. Хүн төрснөөсө хойш үнэний бус мэдлэгийг хураасаар байсан бол бодол санаа нь ч гэсэн эцэстээ үнэний бус байхаас ч өөр аргагүй юм. Хэдий тийм ч гэсэн үнэний бус мэдлэгүүдийг үнэний мэдлэгүүдээр сольж болох бүрэн боломжтой юм.

Үүний тулд хичээнгүйлэн үг сургаалыг сонсож, өөрийн болгох хэрэгтэй юм. Сүнсээр ба үнэнээр мөргөж, цуглаандаа оролцон, зөвхөн “Тийм” ба “Амен” хэмээн үг сургаалыг зүрх сэтгэлдээ бүлгэн авч,өөрийгөө өөрчлөн, хурдан сүнсэлэг ариун байдлыг олсноор үнэний бодлуудаар л дүүрэх болно.

## 2. Бурхантай дайсагнадаг Махан биеийн бодол санаа

Зарим хүмүүс Бурханы үгийг сонсож байхдаа өөрийнх нь бодолд нийцвэл “Амен” гэж хэлдэг ч гэсэн өөрийн мэдлэг туршлагатай нь нийцэхгүй бол “Үгүй, тийм биш ээ” гэж хэлдэг. Тэд үг сургаалд итгэж чадахгүй байгаа бөгөөд Бурханы хүслийн эсрэг бодлуудыг хадгалдаг. Энэ мэт Бурханы хүслийн эсрэг бодлуудыг “махан биеийн бодол санаа” гэж нэрлэдэг бөгөөд сатан хүмүүсийн ийм бодлуудыг бий болгодог.

Библи дээр үзвэл Есүс эцэст нь Бурханы төлөвлөгөөний дагуу загалмайг үүрэх болно гэдгийг айлдах үед , Петр “Эзэн минь Тангь Бурхан өршөөг. Ийм юм Танд хэзээ ч тохиолдохгүй.....” гэж хариулсан тухай гардаг. Энэ нь багшаа хайрласан сэтгэлээр хэлсэн шавийн мэдээжийн хэлэх үг мэт санагдаж магадгүй ч гэвч Петрийн хэлсэн энэ үгс нь Бурханы хүслийг гүйцэлдэхэд саад болсон махан биеийн бодол байсан тул Есүс Петрт хандан “-Миний араас зайл, Сатан аа!.....” гэж хатуу зэмлэснийг харж болно. (Матай 16: 21-23)

Энэ мэт махан биеийн бодол нь арайхан сүнсэлэг бус махан биеийн хүмүүсийн хувьд иймэрхүү үгс мэргэн, ухаалаг ба сайн мэт сонсогдож болох боловч, харин ч ийм бодлууд нь Бурханы эсрэг дайсагнал болдог бөгөөд Бурхантай огт хамаагүй болдог юм. (Ром 8:7).

Би Бурхантай уулснаасаа хойш би махан биеийн бодлууддаа хөтлөгдөн, Бурханы үгэнд ганц ч удаа эргэлзэж байсан удаа байхгүй билээ. Ямар ч эмч нар эмчилж чадаагүй Миний өвчнийг тэр дор нь эдгээж өгсөн Бурханы хүч чадлыг биеэрээ үзсэн бөгөөд мөн Бурхан тэнгэр газрыг бүтээж, нар ба сарыг зогсоож, Улаан тэнгисийг хуваасан гэдэгт болон Есүс үхсэн хүнийг амилуулсан гэдэгт төгс итгэсэн юм.

## 3. Махан биеийн бодлыг хаяж Сүнсэлэг бодлыг авахын тулд

Хүний онол ба мэдлэг нь Бурханы үг сургаалд итгэж чадахгүй, дуулгавартай дагадаггүй бүх бодлууд бүгд махан биеийн бодлууд юм. Тиймд хүмүүс өдөр болгон тоолшгүй олон иймэрхүү махан биеийн бодол санаан дотор амьдардаг тул, тэд бүгдээрээ Бурханы дайсан болдог юм. Тэгвэл бид бодол санаагаар хийсэн гэм нүглүүдээсээ уучлагдахын тулд яах ёстой вэ?

2 Коринт 10: 5 дээр айлдсанчлан “Бид цэцэрхэл болон Бурханы мэдлэгийн эсрэг босогч аливаа өндөрлөг зүйлийг устгаж, ямар ч бодол санааг Христийн дуулгавартай байдалд олзуулдаг” гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, махан биеийн бодол санааг хаях, зөв гэж бодож байсан мэдлэгүүд нь Бурханы үг сургаалтай нийцэхгүй л бол бүгдийн хаях ёстой.

Бид бодол санаагаар хийдэг гэм нүглүүдийг хаяхын тулд, эхлээд зүрх сэтгэлээ ариун болгох хэрэгтэй.

1 Иохан 2:16 бидэнд хэлэхдээ, “Учир нь ертөнцөд байгаа бүхэн тухайлбал, махан биеийн хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал, амьдралын бардам бахдал нь Эцэгээс бус, харин энэ ертөнцөөс ирдэг юм.” гэжээ.

Зүрх сэтгэлд нь хорон муу шинж чанар байгаад зогсохгүй энэ дэлхийн хэв маягийг дагах хүсэл дүүрэн байхад, махан биеийн бодлууд гарах нь ойлгомжтой юм. “Махан хүсэл тачаал” байхад дэлхийн зүйлс нүдэнд сайхан харагдаж тийм зүйлийг даган улмаар автах тусам мах

биеийн хүсэл нь улам гүнзгийрч, махан биеийн үйлсээр хийхийг хүсдэг болохыг харж болно. (Галат 5:19-21).

“Нүдний хүсэл тачаал” гэдэг нь хүн нүдээрээ харж, чихээрээ сонссон зүйлсээр дамжуулан зүрх сэтгэлдээ авснаар улам тэдгээр зүйлс рүү тэмүүлдэг махан биеийн шинж чанар юм. Ийм “нүдний хүсэл тачаал”-аас болж хүмүүс бага багаар дэлхийн зүйлс руу, дур сонирхол, хүсэл тачаалын зүйл рүү тэмүүлж бодож эрэлхийлдэг болдог.

“Амьдралын бардам бахдал нь” бол хүмүүс өөрсдийн зугаа цэнгэл болон тааламжыг эрэлхийлэн, өөрсдийгөө илчлэхийн төлөө бахдан хөөрөх шинжтэй зан чанар юм. Мөн “амьдралын бардам бахдал” улмаас хүмүүсийг өөрсдийгөө өргөмжилж, хүлээн зөвшөөрөгдөх гэх, нэр хүнд, эрх мэдэл,магтаалыг авах, гэсэн алдар эрх мэдлээ зууран барих руу чиглүүлдэг билээ.Тиймээс ийм, махан биеийн хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал, амьдралын бардам бахдалыг хаявал Бурханыг баярлуулах сүнсний бодолтой болох юм.

## 4. Тэнгэрийн оронд үзэсгэлэнт титмүүдийг бэлтгэсэн Бурхан

Есүс өргөст титмийг бидний төлөө зүүсэн учраас бид эцэстээ тэнгэрийн оронд ороходоо үзэсгэлэнтэй сайхан титмүүдийг зүүх болсон юм. Энэ газар дээр бид ямар амьдралаар яаж амьдарснаас шалтгаалж, төрөл бүрийн титэм бидэнд зориулагдан бэлтгэгдсэн байдаг.

Жишээ нь Эзэнийг хүлээн зөвшөөрч, үнэнийг сонсож, гэм нүглээ тэмцэн хаях гэж хичээн зүтгэдэг хүнд өгөгдөх “үл муудах титэм” (1 Коринт 9:25), гэм нүглийг тэмцэн хаяж, үг сургаалын дагуу амьдарч Бурхандаа алдрыг өргөдөг хүнд өгөгдөх “алдарын титэм” (1 Петр 5:4), мөн Бурханыг хайрлан үхэх хүртлээ итгэмжит байж, хорон муугын аливаа хэлбэр бүхнийг бүгдийг хаяж, ариун байдлыг олсон хүнд өгөгдөх “амийн титэм”- (Иаков 1:12, Илчлэлт 2:10) гэх зэрэг байдаг юм.

Түүнчлэн Төгс ариун байдалтай болж, Бурханыг баярлуулах итгэлээр үүргээ сайн гүйцэтгэсэн хүмүүст өгөгдөх “зөвт байдлын титэм” (2 Тимот 4:8) хүртэх билээ. Илчлэлт 4:4д Тэнгэрийн орны ахлагч нарын зүүдэг “алтан титэм” - ийн талаар мөн дурддаг.

Тиймд хайрт итгэгч Та бүхэн Ийм Бурханы агуу хайранд талархаж,ариухан цэвэр зүрх сэтгэлтэй болж, бүх гэртээ итгэмжтэй байж, эцэст нь Шинэ Иерусалимд үзэсгэлэнт титмийг хүлээн авахыг Эзэн Есүс Христийн нэрээр хүсэн ерөөе!

Mongolian

**Манмин Мэдээ**  
Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Севл,  
152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
http://www.manmin.org/english  
e-mail: manminministry@hotmail.com  
Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин

# “Би сүнсэлэг нойрноос сэрж, хөхний хорт хавдараас эдгэрсэн юм”

Хан Ин уг Сүмд үйлчлэгч (1-р их тойрог 4-р бүлэг)



2007 оны 3-р сард гэнэт миний баруун хөхөнд хөндүүрлэн өвдөж тэмгэрч үзэхэд хатуу зүйл мэдрэгдэв. Хөхний хорт хавдартай байх магадлал ихтэй байсан ба итгэж ядан байсаар эмчид үзүүлэхээр эмнэлэг рүү явсан юм. Дахин өөр эмнэлэг рүү очиж нарийн шинжилгээ болон биопси (эд эсийн шинжилгээ) хийлгэв.

Шинжилгээний хариу нь намайг хөхний хорт хавдартай байна гэсэн ба үүнд би огт итгэж чадахгүй байлаа. Нарийн шинжилгээний үр дүнд би хөхний хорт хавдарийн 2 дахь шатанд байснаа олж мэдсэн юм. Тэгсэн ч миний найдвар тасраагүй юм. Бурхан бол бүх зүйлсийг хийж чадна гэдэгт итгэдэг учраас, мөн би Доктор И Жей руг пасторын залбирлуудаар дамжуулан үй олон итгэгчид өвчнүүдээсээ эдгэрэхийг харсан

тул огтхон ч эргэлзсэнгүй. Эмч нар намайг хэвтэж хагалгаанд хагалаанд ор гэсэн ч би Бурханд даатгаар шийдсэн юм. Тэгээд Доктор И Жей руг пасторын залбирлыг хүлээн авсны дараа өвдөлт минь байхгүй болов.

Гэвч хорт хавдрыг үндсээр нь эдгэрээгүй болохоор хэсэг хугацааны дараа дахиад өвдөлтийг мэдрэв. Хүчтэй өвдөх үедээ хутгаар хатгах мэт ихээр өвддөг байв.Бага багаар миний баруун гар хүчгүй болж, савх ч бас хэрэглэж чадахааргүй болов.Тэгэхэд би өөрийн итгэлийн амьдралаа эргэн харж эхлэв.

Би Доктор И Жей руг пасторын «Загалмайн Үг» «Арван гай гамшиг» «Итгэлийн хэмжээ» номуудыг уншиж «Хайрын бүлэг» ба «Ариун Сүнсний есөн жимс» гэсэн сургаалын кассетуудыг сонсоходоо Бурханыг харахад зүрх сэтгэлд минь зөв бус зүйлсийг олохыг хичээсэн билээ. Өнгөрсөн хугацаанд би олон сургаалуудыг сонсоод өөрийгөө итгэлтэй гэж андуурч байсан анзаарч, зүрх сэтгэлийнхээ хөрсийг хагалж чадаагүй, байснаа ухаарсан юм.

Би зүрх сэтгэлдээ бардамнах, үзэн ядах, тавгийрхэх, гомдон гоморхох, болон бусад хүнд буруугаа чихэх байдал болон Бурханд итгэхээсээ өмнө хиймэл шүтээн шүтэж байснаа хүртэл үнэхээр эргэн санаан чин сэтгэлээсээ гэмшсэн юм. Тэгэхэд гайхалтай нь гэмших бүрт өвчин хөндүүр минь багассаар, нэг л мэдэхэд би эдгэрсэн байх нь гэж бологдог боллоо.

2009 оны 7 сарт би дахиад (эд эсийн шинжилгээ) хийлгэв. Хариу нь надад хорт хавдарын шинж тэмдэг хэвээрээ байна гэж гарав. “Арай л болоогүй юм байна” гэж санаа унахын оронд Бурхан намайг харж байгаа, дэмжиж байгаа гэдэгт итгэж байгаа учраас харин ч би талархан залбирч байлаа. Би Бурханд, «Бурхан Эцэг минь! Намайг ийм ихээр хайрладагт тань талархъя. Би бүр илүүгээр өөрчлөгднө. Хурдан өөрчлөгднө.» гэж залбиран Түүний намайг хайрлах хайрыг бодоход нулимс минь тогтохгүй байлаа. Үүний дараа би өмнөх сан харьцаагаа өөрчилж Эзэний хайр ба сайн зүрх сэтгэлийг дуурайхын тулд илүү шаргуу зүтгэж байв.

Нэгэн өдөр би зүүдэндээ Доктор И Жей руг пасторын, эдгэрлийн гэрэл над руу орж ирж байна хэмээн надад хэлж байгааг зүүдлэв. Тэр үед найдвар төрж, Есүсийн хувцасны хормойноос л барьснаараа л 12 жилийн цус алддаг өвчнөөсөө эдгэрсэн эмэгтэй шиг Доктор И Жей руг пасторын гарнаас барьснаараа өвчнөөсөө эдгэрэх болно гэсэн итгэлтэй болсон юм.

Өнгөрсөн 5 сард би итгэлээрээ Доктор И Жей руг пастортой гар барьсны дараа хавдар минь багассныг мэдрэсэн юм. 6 сарын 10-нд Онцгой Эдгэрэл Ивээлийн цуглааны эхний өдөр залбирал авсны дараа хавдраа тэмгэрч үзэхэд бараг мэдрэгдэхгүй байлаа. 6 сарын 24-нд би Онцгой Эдгэрэл Ивээлийн цуглааны 3 дахь өдөр дахин залбирал авсны дараа 6 сарын 29-нд дахиад шинжилгээ өгөв. Шинжилгээний үр дүн нь намайг хавдаргүй байгаа гэж илэрхийлсэн бөгөөд хавдарын булцуу нь харагдахгүй болсон ба хавдрын ул мөр л үлдэх хэмжээний болсон байв. Халлелуяа!

▲ Залбиралын өмнө  
2009 оны 7 сарын  
2 Шинжилгээний үр  
дүн  
Хөхний хорт хавдар  
2.5 см

▲ Залбирлын дараа  
2009 оны 29 сарын  
2011 Шинжилгээний  
үр дүн  
Хөхний хорт хавдрын  
ул мөр л байгаа  
байдал

# “Би сүнсэлэг Эцэгтэйгээ уулзсанаас хойш номлолын ажил минь аз жаргалтай”

Мулэнга Тумба Тоши Пастор (Израйль, Ирээд Үз Манмин Сүм)



Пасторуудын Семинарыг явуулсан бөгөөд тэр үед эдгэрлийн үйлс тэнд агуу ихээр гарлаа. Тэр үед би нэгэн үзэгдлийг харсан юм. Үзэгдэлд, би сандал дээр сууж байсан бөгөөд би хаашаа явах ёстойгоо мэдэхгүй их л тээнгэлзэж байв. Гэнэт Доктор И Жейрок пастор гараа аав шиг минь над руу сунгахад би явах замаа хайх мэт түүн дээр очив. Яг тэр агшинд намайг сүнсэлэг эцэгтэй уулзсана гэсэн эш үзүүлэгчийн үгс надад эргэн санагдсан билээ.

Тэр өдрөөс эхлэн би интернетэд гардаг Доктор И Жейрок пастор сургаалуудыг сонсож эхлэв. Би «Тэнгэрийн орон 1, 2» «Итгэлийн хэмжээ» «Там» гэдэг түүний номуудыг ихэд шимтэн уншиж байхад тэдгээн номон дотор сүнс зүгийн нууцууд дүүрэн байлаа. Би өдөр тогтмол үг сургаал сонсож, залбирахад өөрийн итгэлийг хурдан өсч байгааг мэдрэсэн юм.

Би огтхон ч эргэлзэлгүй өөрийн сүмээ Манмин төв сүмийн салбар сүм болохоор бүртгүүлж нэрийг нь “Ирээд Үз Манмин Сүм” гэж өөрчилж, Доктор И Жейрок пасторынзалбирал хийж өгсөн эрх мэдэлт хүчтэй гар алчуураар (Үйлс 19:11-12) өвчтэй хүнд залбирал хийж өгөхөд минь эдгэрсэн олон хүмүүсийг харахдаа би өөртөө итгэлтэй болж номлол хийхэд аз жаргалтай байна. Халлелуяа!

Доктор И Жейрок пастор дахиад Израйльд ирж